ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

# ГААЛИЙН БОЛОН БУСАД АЛБАН ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ ШИНЭ МЭДЭЭЛЭЛ

ТАТВАРЫН ОРЛОГЫН ГАЗАР

# АГУУЛГА:

НЭГ. ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

ХОЁР. ГААЛИЙН ТАРИФ, ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ

ГУРАВ. ТАТВАРЫН ЦАХИМ ТОДОРХОЙЛОЛТ

# НЭГ. ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

| Горим | Агуулга | Тайлбар | |
|---|---|---|---|
| 401 | Олон улсын гэрээний дагуу гаалийн болон бусад албан татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах<br>ГТГТТХ-38.1.2, 38.1.10, 38.1.11<br>НӨАТ-13.1.2, | Олон улсын байгууллага, түнш орноос Засгийн газрын шугамаар, эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хүрээнд оруулах бараа Жишээ нь: Хандивлагч олон улсын байгууллагаас илгээсэн тусламжийн бараа, Хоёр орны ЗГ-ын түвшинд хийсэн гэрээ хэлэлцээрийн хүрээнд оруулах бараа, ОУ-ын гэрээний дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй төлөөлөгчийн газрын албан хэрэгцээний зориулалттай бараа гэх мэт | Гаалийн Ерөнхий газрын албан бичиг. |
| 402 | Гадаад орны засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний дагуу гаалийн болон бусад албан татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах | Зөвхөн хоёр орны ЗГ хороондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төсөл арагаа хэмжээний хүрээнд оруулах бараа<br>ГТГТХ- 38.1.13, НӨАТ-13.1.3 | |
| 403 | Монгол улсын хуулийн дагуу гаалийн болон бусад албан татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж, дотоодын хэрэглээнд зориулан оруулах | ГТГТХ-38, НАӨТ-13 дугаар зүйлд заасан дээрх зүйл заалтаас бусад бараа болон бусад хуулиар зохицуулсан бараа. | - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, хиймэл эд эрхтэн, эд анги, тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгсэл,<br>- Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн,<br>- Зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэх, байлууллагын хэрэгцээнд зориулан импортоор оруулж байгаа зэвсэг, тусгай техник хэрэгслийг НӨАТ-аас чөлөөлөхөөс бусад тохиолдолд газар хороод дээр шийдвэрлэнэ. |

| Чөлөөлөгдөх бараа | Татвараас чөлөөлөх үндэслэл, хуулийн заалт | Татварын төрөл | Хугацаа | Бүрдүүлэлтэд шаардлагатай албан бичиг |
|---|---|---|---|---|
| Импортоор оруулах бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал | “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.7 дахь заалт;<br>“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.20 дахь заалт; | Гааль, НӨАТ | - | Хуулийн заалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, хиймэл эд эрхтэн, тэдгээрийн эд анги, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын авто тээврийн хэрэгсэл | “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.1 дахь заалт;<br>“Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.12 дахь заалт;<br>“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.4 дахь заалт; | Гааль, НӨАТ | - | ГЕГ-ын дарга болон дэд даргын гарын үсэг бүхий албан бичиг шаардана. |
| Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн | “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.5 дахь заалт;<br>“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.8 дахь заалт; | Гааль, НӨАТ | - | |
| Хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, механизм, техник, хэрэгсэл, тоноглол | “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.6 дахь заалт;<br>“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.9 дахь заалт; | Гааль, НӨАТ | - | Засгийн газрын 2015.12.21-ний өдрийн 503 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл | 2017.02.02-ны өдрийн “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль; | Гааль | 2018.12.31 хүртэлх хугацаанд мөрдөнө. | Засгийн газрын 2017.06.14-ний өдрийн 168 дугээр тогтоолын хавсралт дээрх жагсаалтыг дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |

| Чөлөөлөгдөх бараа | Татвараас чөлөөлөх үндэслэл, хуулийн заалт | Татварын төрөл | Хугацаа | Бүрдүүлэлтэд шаардлагатай албан бичиг |
|---|---|---|---|---|
| Томуугийн А хүрээний /H1N1/ вирусын халдварын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис | 2009.10.30-ны өдрийн “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль; “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль; | Гааль, НӨАТ | - | Засгийн газрын 2009.11.04-ний өдрийн 335 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Импортоор оруулах хориглосноос бусад мод, сөөгний үр, тарьц, суулгац | “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.7 дахь заалт; | Гааль | - | Хуулийн заалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулах шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис | 2016 оны 02–р сарын 5-ны өдрийн "Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай" хууль; | НӨАТ | 2020.12.31 хүртэлх хугацаанд мөрдөнө. | Засгийн газрын 2016.04.04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг | “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.18 дахь заалт; “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.28 дахь заалт; | Гааль, НӨАТ | - | Засгийн газрын 2016.04.04-ний өдрийн 198 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах зорилгоор импортоор оруулж байгаа агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмж | 2018.01.12-ны өдрийн “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль; ”Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль; | Гааль, НӨАТ | | Засгийн газрын 2018.05.30-ны өдрийн 157 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу гаалийн газар хороод дээр татвараас чөлөөлөгдөнө. |
| Импортоор оруулж байгаа гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалтын мод, зүүш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц | 2018.05.10-ны өдрийн “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль, “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль, | Гааль, НӨАТ | 2022.12.31 хүртэлх хугацаанд мөрдөнө. | Засгийн газар тогтоол батална. 2019.01.01-нээс мөрдөж эхэлнэ. 2018.01.01-2018.12.31 хүртэлх хугацаанд төлсөн татварыг буцаан олгоно. |

# ЖДҮ-д ТАВИГДАХ ШААРДЛАГА

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч гэдэгт дараах шаардлагыг хангасан, энэ хуулийн 6.6-д заасны дагуу бүртгүүлсэн аж ахуйн нэгж, иргэнийг ойлгоно:

✓Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь **199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг** хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;

✓**149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг** хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий **бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн**;

✓**199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг** хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий **жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;**

✓**49-өөс дээшгүй бөгөөд 1 тэрбум төгрөг** хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий **үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;**

✓19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, **50-250 сая төгрөг** хүртэлх жилийн борлуулалтын орлого **бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн.**

## 2018 ОНД ШИНЭЭР БАТЛАГДСАН ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

- **Нийслэлийн** агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах зорилгоор импортоор оруулж байгаа агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн.
  - 2018.01.12-ны өдрийн Монгол Улсын хууль,
  - 2018.05.30-ны өдрийн Засгийн газрын 157 тоот тогтоол

## 2019 ОНООС ХЭРЭГЖИХ ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

- Импортоор оруулж байгаа гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалтын мод, тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. /2018 онд импортолсон дээрх барааны татварыг 2019.01.01-нээс буцаан олгоно./
  - 2018.05.10-ны өдрийн Монгол Улсын хууль
  - Засгийн газрын тогтоол батлагдаагүй байгаа

- Спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл.
  - 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хууль
  - Засгийн газрын тогтоол батлагдан гараагүй

- *төхөөрөмж, хэрэглэл.*

# ХОЁР. ТАРИФ, ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ

# 2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС ХУВЬ, ХЭМЖЭЭ НЬ ӨӨРЧЛӨГДӨХ ТАТВАРУУД

*Онцгой албан татварын тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар 2018, **2019**, 2020 болон түүнээс хойш онд мөрдөх онцгой албан татварыг дараах хувь, хэмжээгээр баталсан. Үүнд:*

| ОНЦГОЙ АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ БАРААНЫ НЭР, ТӨРӨЛ | | Биет нэгж | Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/ | |
|---|---|---|---|---|
| | | | 2018 он | 2019 он |
| Хүнсний зориулалттай спирт | Согтууруулах ундааны үйлдвэрт худалдсан | 1 литр | 1'595 | 1'670 |
| | Эмийн үйлдвэр, хүн, мал эмнэлгийн хэрэгцээнд худалдсан | 1 литр | 1'450 | 1'450 |
| | бусад газарт худалдсан | 1 литр | 15'950 | 16'700 |
| Бүх төрлийн цагаан архи,ликёр,кордиал ба спиртлэг бусад ундаа | 25 хүртэл хатуулагтай | 1 литр | 3'190 | 3'335 |
| | 25-40 хүртэл хатуулагтай | 1 литр | 6'380 | 6'670 |
| | 40 ба түүнээс дээш хатуулагтай | 1 литр | 14'355 | 15'000 |
| Бүх төрлийн коньяк, виски, ром, джин | 25 хүртэл хатуулагтай | 1 литр | 7'975 | 8'340 |
| | 25-40 хүртэл хатуулагтай | 1 литр | 15'950 | 16'700 |
| | 40 ба түүнээс дээш хатуулагтай | 1 литр | 19'140 | 20'010 |
| Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан эх орны үйлдвэрийн шимийн архи | | 1 литр | 320 | 335 |

# 2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС ХУВЬ, ХЭМЖЭЭ НЬ ӨӨРЧЛӨГДӨХ ТАТВАРУУД

*Онцгой албан татварын тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар 2018, **2019**, 2020 болон түүнээс хойш онд мөрдөх онцгой албан татварыг дараах хувь, хэмжээгээр баталсан. Үүнд:*

| ОНЦГОЙ АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ БАРААНЫ НЭР, ТӨРӨЛ | | Биет нэгж | Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/ | |
|---|---|---|---|---|
| | | | 2018 он | 2019 он |
| Бүх төрлийн дарс | 35 хүртэл хатуулагтай | 1 литр | 800 | 835 |
| | 35 ба түүнээс дээш хатуулагтай | 1 литр | 7’180 | 7’505 |
| Бүх төрлийн пиво | | 1 литр | 320 | 335 |
| Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи | | 100 ш | 3’830 | 4’000 |
| Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи | | 1 кг | 2’870 | 3’000 |
| Автобензин | 90 хүртэл октантай | 1 тонн | 0-15’950 | 0-15’950 |
| | 90 ба түүнээс дээш октантай | 1 тонн | 0-17’400 | 0-17’400 |
| Дизелийн түлш | | 1 тонн | 0-21’750 | 0-21’750 |

# ГААЛИЙН ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ – 2019 онд

1. Монгол – Японы ЭЗТХэлэлцээрийн **тарифын хөнгөлөлт 2019.04.01**-ний өдрөөс 4 дэх үе шатны хөнгөлөлт хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, хэлэлцээрээр тохирсон импортын 5700, экспортын 9300 орчим бараанд 2 орон тарифын хөнгөлөлт үзүүлж, жил бүрийн 4 дүгээр сарын 1-нд үе шаттайгаар гаалийн тарифаа бууруулахаар тохирсон байна.

2. Европын холбоонд бараа бүтээгдэхүүнээ Хөнгөлөлтийн ерөнхий систем (**GSP+**)-ийн дагуу “тарифын хөнгөлөлт”-тэй нөхцлөөр экспортлох компаниудын “**REX / Бүртгэгдсэн экспортлогчдын систем**”-ийг хэрэгжүүлж эхлэнэ. *(Шилжилтийн хугацаа 1 жил)*

3. Ази, Номхон далайн хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр (**АПТА**)-г хэрэгжүүлнэ. Гишүүн орнууд: Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланк Улс. *(Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг ЗГ-аас УИХ-д өргөн барьсан.)*

# ГУРАВ. ТАТВАРЫН ЦАХИМ ТОДОРХОЙЛОЛТ

# ГААЛИЙН ТАТВАРЫН ӨРТЭЙ ЭСЭХ ТОДОРХОЙЛОЛТ ЦАХИМЖЛАА

ГЕГ-ын даргын 2018-07-06 өдрийн А/133 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу тодорхойлолтыг цахимаар олгоно .

- Тодорхойлолтын дугаар автоматаар үүсч хадгалагдана.
- QR кодоор баталгаажих тул-Тамга, гарын үсэг шаардлагагүй
- http://portal.ecustoms.mn хаягаар тодорхойлолт авах болон шалгана.

Татвар, Улсын бүртгэл, Шүүх, Цагдаа зэрэг төрийн байгууллага мөн хаягаар хандан аж ахуйн нэгжийн өртэй эсэх тодорхойлолтыг цахимаар харах боломжтой.

❖ААН татан буугдах- 80%

❖ Хууль зүйн дүгнэлт, магадлан шинжилгээ гаргуулахаар хуулийн компанид хандснаас тодорхойлолт шаардлагатай болсон -18%

❖ Тендерт оролцохоор-2%

- Тодорхойлолт дараах 2 төрөлтэй байна.


МОНГОЛЫН ГААЛЬ

Тодорхойлолт

| | |
|---|---|
| ААН, Иргэн: | Грийн-Органик ХХК |
| Регистр №: | 5347505 |
| Тодорхойлолтод хамаарах огноо: | 2016.01.01 - 2018.12.03 |
| Бүрдүүлэлт хийсэн эсэх: | Үгүй |

*Тайлбар:* Улсын бүртгэлийн 5347505 тоот регистрийн дугаартай "Грийн-Органик ХХК" нь дээрх хугацаанд гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн мэдээлэл гаалийн мэдүүлгийн санд бүртгэгдээгүй тул татварын өргүй болохыг тодорхойлов.

Тодорхойлолт гаргасан огноо: 2018-12-03

Тодорхойлолтын дугаар: T18V4H2RH

http://portal.ecustoms.mn/CEPS/checkT.jsp хаягаар тодорхойлолтоо шалгана уу.


МОНГОЛЫН ГААЛЬ

Тодорхойлолт

| | |
|---|---|
| ААН, Иргэн: | Арш ХХК |
| Регистр №: | 2097877 |
| Тодорхойлолтод хамаарах огноо: | 2016.01.01 - 2018.12.03 |
| Бүрдүүлэлт хийсэн эсэх: | Тийм |

*Тайлбар:* Гаалийн Ерөнхий Газарт албан хүсэлтээр хандан мэдээллийг авна уу.

Тодорхойлолт гаргасан огноо: 2018-12-03

Тодорхойлолтын дугаар: T183U5P3W

http://portal.ecustoms.mn/CEPS/checkT.jsp хаягаар тодорхойлолтоо шалгана уу.

- Гаалийн мэдээллийн санд бүртгэлгүй тохиолдолд цахим тодорхойлолт шууд гарна.
- \- Татварын тооцоотой аж ахуйн нэгжийн талаарх мэдээлэлийг гаалийн ерөнхий газарт хандаж авна.

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

**2018 он**